



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 09 сарын 09 өдөр

Дугаар A/457

Улаанбаатар хот

Г Эмнэлзүйн заавар боловсруулах  
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1, 37.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлзүйн заавар боловсруулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, гишүүд, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт үүрэг болгосугай.
3. Боловсруулах шаардлагатай эмнэлзүйн зааврын төлөвлөгөөг жил бүр гарган батлуулахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т даалгасугай.
4. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т даалгасугай.
6. Энэхүү тушаал хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/477 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД

С.ЭНХБОЛД



141222125

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дугаар сарын 09-өдрийн 157 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1 Эмнэлзүйн зааврыг шинээр боловсруулах, шинэчлэхдээ оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинэлэг арга, туршлага, эрүүл мэндийн технологийн үнэлгээний дунд үндэслэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Эмнэлзүйн заавар гэдэг нь аливаа өвчин эмгэгийг оношилох, эмчлэхэд ашиглах аргыг нотолгоонд суурилсан анагаах ухаанд тулгуурлан зохион байгуулалт, дэс дараалалтайгаар нарийвчлан заасан нэгдмэл мэдээлэл бүхий баримт бичиг юм.

1.3 Эмнэлзүйн зааврыг боловсруулахдаа “Зохион байгуулалт захирамжлалын баримт бичиг” MNS 5140-2:2021 стандартын 2 дугаар хэсэг. “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага”, 3 дугаар хэсэг. Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага”-ыг тус тус дагаж мөрдөнө.

### Хоёр. Эмнэлзүйн заавар боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт


2.1 Төрийн захиргааны төв байгууллагын эмнэлзүйн зааврын асуудал эрхэлсэн газар, нэгж нь эмнэлзүйн зааврыг боловсруулах ажлыг ерөнхий удирдлага, арга зүйгээр хангаж, боловсруулсан төсөлд бусад холбогдох байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоодын санаалд тулгуурлан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна.

2.2 Эмнэлзүйн зааврыг эрүүл мэндийн яам, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоодоос санаачлан боловсруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилно.

2.3 Томилогдсон ажлын хэсгийг бүрдүүлэхдээ 5-аас доошгүй жил тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, эмч, сувилагч нарын төлөөлөл, холбогдох мэргэжлийн нийгэмлэг, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын төлөөлөл гэх зэрэг олон талын оролцоог хангана.

- 2.4 Эрүүл мэндийн салбарт эмчилгээ, оношилгооны шинэ технологи, арга аргачлал нэвтрүүлэхдээ эмнэлзүйн заавар эсвэл стандарт батлуулсан байна.
- 2.5 Эмнэлзүйн зааврыг боловсруулахдаа нотолгоонд суурилсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн заавар, стандартыг суурь болгож ашиглана.
- 2.6 Өвчний хэлбэр, үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний онцлогоос хамаарах оношилгоо, эмчилгээний зайлшгүй хийх тусламж, үйлчилгээ, гүйцэтгэх ажилбар, гардан үйлдэл, зөвлөгөөг эмнэлзүйн зааварт тусгана.
- 2.7 Оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг тодорхой нарийвчлан зааж, эм, биобэлдмэлийг олон улсын нэршлээр бичнэ.
- 2.8 Эмнэлзүйн зааварт ашигласан, ишлэл авсан материал, баримт бичгийн жагсаалтыг хавсаргана.
- 2.9 Эмнэлзүйн зааврын хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ-үнэлгээний дүнг нийтэд нээлттэй байлгана.
- 2.10 Эмнэлзүйн зааврыг олон улсад зөвшөөрөгдсөн шинэ технологи, арга туршлага нэвтэрсэн тухай бүрд судлан шинэчилнэ.
- 2.11 Эмнэлзүйн зааварт хэрэглэгдэж байгаа мэргэжлийн үг хэллэг, нэр, томьёо нь хоёрдмол утга санаагүй, ойлгогдохуйц байна.
- 2.12 Эмнэлзүйн заавар батлагдсан даруйд эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэн, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулан хүртээл болгоно.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09.  
дугаар сарын 09. өдрийн 14:57 дугаар  
тушаалтын хоёрдугаар хавсралт



## ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

### A. ЕРӨНХИЙ ШАРДЛАГА

- A.1 Онош эсвэл хам шинж
- A.2 Өвчний олон улсын 10-р ангилал болон үйлдлийн олон улсын 9-р ангилал
- A.3 Хэрэглэгчид
- A.4 Зааврын зорилго, зорилт
- A.5 Тодорхойлолт
- A.6 Тархвар зүйн мэдээлэл
- A.7 Үндсэн ойлголт
- A.8 Өвчний тавилан
- A.9 Үйлчлүүлэгчид өгөх зөвлөгөө
- A.10 Эрсдэлт хүчин зүйлс

### B. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

- B.1 Эрүүл мэндийн анхан шатны болон лавлагаа тусlamж, үйлчилгээ бүрт эрт илрүүлэг зохион байгуулах
- B.2 Зорилтот бүлэг
- B.3 Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө
- B.4 Эрт илрүүлэг хийх арга техник

### B. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ /АЛГОРИТМ/

- B.1 Зовиур, эмнэлзүйн шинж

В.2 Ерөнхий болон бодит үзлэг, багажийн шинжилгээ

В.2.1 Дурдатгал /анамнез/

В.2.2 Бодит үзлэг

В.2.3 Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусlamж үзүүлэх шалгуур

В.2.4 Лабораторийн шинжилгээ

В.2.5 Багажийн шинжилгээ

В.2.6 Оношилгооны шалгуур

В.2.7 Ялган оношилгоо

В.3 Шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчийг хянах аргазүй

В.3.1 Лабораторийн шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үеийн алгоритм

В.3.2 Багажийн шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үеийн алгоритм

В.4 Оношилгоонд шаардлагатай зурган жишээ

В.5 Эмчилгээ

Б.5.1 Эмийн бус эмчилгээ /заалт, эмчилгээ үргэлжлэх хугацаа, хүндэрэл, анхаарах заалт/

Б.5.2 Эмийн эмчилгээ /Эмийн нэрийг олон улсын нэршлээр бичнэ. Нэгдүгээр сонголтын эм, дараагийн сонголтын эмийн тун хэмжээ, тун хоорондын зайд, эмчилгээ үргэлжлэх хугацаа, анхаарах заалт, хоруу нөлөөний тухай мэдээлэл/

Б.5.3 Мэс засал эмчилгээ /Заалт, нөхцөл, бэлтгэл, арга техник, мэс заслын өмнө, явцад болон дараа тавих хяналт/

Б.5.4 Эмчилгээний алгоритм

В.6 Үйлчлүүлэгчийн дараагийн шатны эмчид илгээх зарчим, шалгуур

## Г. ХЯНАЛТ

Г.1 Ерөнхий ойлголт

Г.2 Эмчилгээний дараах анхан, лавлагаа шатлалын эмчийн хяналтад байх хугацаа

Г.3 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчийг хянахад анхаарах асуудлууд

Г.4 Яаралтай шинж илэрвэл эмнэлэгт хандах мэдээлэл

Г.5 Үйлчлүүлэгчид олгох эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө  
ХАВСРАЛТУУД

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ  
НОМ ЗҮЙ